

АГУУЛГА



Бүртгэлтэй ажилгүйчүүд



Эрүүл мэнд



Банк



Төсөв



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ



Хөдөө аж ахуй



Аж үйлдвэр



Бусад

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ


(2021 оны 1 дүгээр сарын байдал)

I. ХӨДӨЛМӨР

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН


Халамжийн үйлчилгээний газарт ажил хайж бүртгүүлсэн иргэд 2021 оны 1 дугаар сарын эцэст 970 байгаагийн 652 (67.2 %) ажил хөдөлмөр эрхлээгүй бүртгэлтэй иргэн, 318 (32.8%) одоо ажил хөдөлмөр эрхлэж байгаа ч бүртгэлтэй иргэн байна. Нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 243 (33.4%) хүнээр өсөж, өмнөх сараас 26 (2.6%) хүнээр буурч, бүртгэлтэй ажилгүй иргэдийн 457 (47.1%) эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газарт ажил хайж байгаа иргэд




Аймгийн хэмжээнд ажилгүй иргэдийн 21 (2.2%) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа ба 8 (38.1%) эмэгтэйчүүд байна.

2021 оны 1 дүгээр сард ажилгүй 124 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 11 иргэн ажилд зуучлагдан орж, 150 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэдийн хувьд ажил хайж буй шалтгаанаар нь задлан харахад хамгийн өндөр хувийг сургууль төгссөн иргэд 20.2 хувь нь, хамгийн бага хувийг цэргээс халагдсан иргэд буюу 0.8 хувь нь эзэлж байна.



Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 50.1 хувийг бүрэн дунд, 31.0 хувийг дипломын болон бакалаврын дээд, 7.0 хувийг техник мэргэжлийн, 4.9 хувийг суурь, 3.7 хувийг тусгай мэргэжлийн дунд, 2.0 хувийг бага, 1.3 хувийг ямар ч боловсролгүй иргэд эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйс дүнд эзлэх хувиар,
2021 оны 1 дүгээр сарын эцэст



Мөн аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 46.6 хувийг 15-34 насны залуучууд, 46.8 хувийг 35-54 насныхан, 6.6 хувийг 55 дээш насныхан тус тус эзэлж байна.

2021 ОНЫ 1 САРД АЖИЛД ОРСОН ХҮН

NUMBER OF UNEMPLOYED ENTERED INTO WORK, in the 1 months of 2021

| Сар Month | Бүгд Total | Төрийн өмчит үйлдвэрийн газарт | Төрийн төсөвт байгууллагад Government organization | Компани Company | Хоршоо Cooperative | Бусад Other |
|--------------|---------------|--------------------------------------|---|--------------------|-----------------------|----------------|
| 1 | 11 | | 9 | 2 | | |

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ:

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.


БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД: Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

II. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

НИЙГМИЙН ДААТГАЛ


Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 1 сард 1 тэрбум 277.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 274.3 (17.7%) сая төгрөгөөр буурч, сангийн зарлага 3 тэрбум 396.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 651.6 (23.7%) сая төгрөгөөр өслөө. Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 651.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 559.2 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Зураг.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага эхний 1 сард, сая төгрөг




Нийгмийн даатгалын сангийн орлогыг сангуудаар нь авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн орлого 127.8 (12.6%), эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 88.0 (28.7%), ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 30.5 (32.8%), тэтгэмжийн даатгалын сангийн орлого 21.3 (19.0%), ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 6.7 (29.7%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, эхний 1 сард, сая төгрөг



Зураг 3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, эхний 1 сард сая төгрөг



Тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 559.2 (21.3%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 60.2 (71.9%), үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 1.7 (32.1%), ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 30.6 (1.1 дахин) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалд даатгуулагчид 2021.I сар

| Үзүүлэлт | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид /тоо/ |
|---|---|
| Нийгмийн даатгалд даатгуулагчид | |
| Бүгд | 10952 |
| Заавал даатгуулагчид | 7616 |
| Сайн дураар даатгуулагчид | 830 |
| Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид | 2506 |

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Нийгмийн халамжийн сангаас 2021 оны 1 дүгээр сард 2.6 мянган иргэнд 551.6 сая төгрөг олгожээ. Үүнээс нийгмийн халамжийн үйлчилгээний зардалд 534.3 сая төгрөгийг зарцуулжээ.

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ:

НИЙГМИЙН ДААТГАЛ НЬ иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН НЬ ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.


Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

III.ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд 2021 оны эхний 1 сарын байдлаар 107 эх амаржиж, 108 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 6 (5.9%)-аар, амьд төрсөн хүүхэд 7 (6.9%)-аар тус тус өссөн байна.


Зураг.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо эхний 1 сараар



Жирэмсний хяналтад шинээр 103 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 94.2 хувь нь эхний 3 сартайд, 5.8 хувь нь 4-6 сартайд хяналтад орсон байна. Амьд төрсөн хүүхдийн 3.7 хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төрсөн. Амьд төрсөн хүүхдийн 64 буюу 59.3 хувь нь хүү, 44 буюу 40.7 хувь нь охин байна. Амьд төрсөн хүүхдийн 5.6 хувь нь дутуу төрсөн байна.


Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл 1 сард 3 гарч, 1000 амьд төрөлтөнд нялхсын эндэгдэл 27.9 ноогдож байна.

Зураг 2.1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар



Нас баралтын 21 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2 (10.5%) тохиолдлоор өссөн байна. Нас баралтын 6 (28.6%) тохиолдол нь эмнэлэгт нас барсан бөгөөд 50.0 хувь нь хоног болоогүй байна. Нас баралтын 6 (28.6%) хорт хавдрын, 5 (23.8%) осол гэмтлийн шалтгаантай байна.

Зураг 3. Нас баралт хүйсээр дүнд эзлэх хувиар




Хорт хавдрын өвчлөл шинээр 1 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 3 (75.0%)-аар буурч, хорт хавдрын өвчлөлөөр бүртгэлтэй байсан өвчлөгчдөөс 6 нас баралт бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 (2 дахин) өссөн байна.

Аймгийн хэмжээнд эмнэлэгт 981 мянган үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 7.2 мянган ор хоног ашигласан ба дундаж ор хоног 7.3 байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 19 болж, өмнөх оны мөн үеэс 7 (26.9%)-аар буурахад бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөгчид 6 (33.3%) буурсан нь голлон нөлөөлсөн байна. 6 төрлийн 19 цочмог халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10.000 хүн амд 3.3 байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн эхний 1 сарын байдлаар



Халдварт өвчний төрлөөр 2021 оны 1 сарын байдлаар



ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ:

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гаргаж авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөх болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.


Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Төсвийн орлого

Орон нутгийн төсөвт нийт 822.6 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 110.5 хувиар биелүүлсэн байна. Үүнээс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 679.8 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 108.5 хувиар, хөрөнгийн 0.7 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 100 хувиар, татварын бус орлого 62.1 төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 113.6 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх 142.8 сая төгрөг, татварын орлого 617.1 сая төгрөгийн орлогыг тус тус оруулсан байна.

Аймгийн төсөвт байгууллагууд авлагагүй, 27.5 сая төгрөгийн өглөгтэй байна.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, мянган төгрөгөөр 2021 оны I сард



Төсвийн зарлага

2020 оны 1 сард орон нутгийн нийт төсвөөс төсвийн зарлага санхүүжилтийн 5.6 хувийг санхүүжүүлсэн байна. Үүнд бараа, ажил үйлчилгээний зардлын 6.7 хувь, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 7.7 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 7.1 хувь, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 8.1 хувь, хангамж, бараа материалын зардлын 2.6 хувь, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын 0.8 хувь, эд хогшил, урсгал засварын зардлын 4.5 хувь, томилт, зочны зардлын 1.5 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын 2.7 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын 3.6 хувь, урсгал шилжүүлэгийн 8.8 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА ХУВИАР 2021 оны I сард



Ойлголт, тодорхойлолт:

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2021 оны 01 дүгээр сард 1 тэрбум 759.5 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өсчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 181.2 сая төгрөг буюу нийт үйлдвэрлэлийн 10.3 хувь, боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 95.9 сая төгрөг буюу 5.4 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 1 тэрбум 401.3 сая төгрөг буюу 79.6 хувь, усан хангамж, сувагжуулалтын системийн үйлдвэрлэл 81.2 сая төгрөг буюу 4.6 хувийг тус тус эзэлж байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, сая төгрөг



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2021 оны 01 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1 тэрбум 741.9 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар буурчээ. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 203.7 (11.7%), боловсруулах аж үйлдвэрийн салбарын борлуулалт 115.3 (6.6%) сая төгрөг, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрийн салбарын борлуулалт 1 тэрбум 356.9 (77.9%) сая төгрөг, усан хангамжийн салбарын борлуулалт 65.9 (3.8%) сая төгрөг байна.

| Салбар | 2020 | | 2021* | | Дүнд эзлэх хувь |
|---|------------------|------------------|------------------|------------------|-----------------|
| | I | I-XII | I | I-XII* | |
| Нийт дүн | 1862193.9 | 1862193.9 | 1741878.6 | 1741878.6 | 100.0 |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 335715.6 | 335715.6 | 203676.5 | 203676.5 | 11.7 |
| Боловсруулах аж үйлдвэр | 129180.9 | 129180.9 | 115336.0 | 115336.0 | 6.6 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж | 1397297.4 | 1397297.4 | 1422866.1 | 1422866.1 | 81.7 |

Ойлголт, тодорхойлолт:

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс Говь-Алтай аймгийн хэмжээнд 2021 оны 1 сард өмнөх оны мөн үеэс 3.0 хувь, өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИНДЕКС, бүлгээр,

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | 2021-1 | 2021-1 |
|---|--------------|--------|---------|
| | | 2020-1 | 2020-12 |
| Ерөнхий индекс | 100.0 | 103.0 | 100.5 |
| Хүнсний бараа, ундаа, ус | 29.3 | 109.8 | 101.6 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.2 | 101.9 | 100.5 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.1 | 104.6 | 100.0 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 12.3 | 100.5 | 100.0 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.7 | 105.6 | 101.5 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 104.6 | 100.0 |
| Тээвэр | 12.2 | 94.6 | 100.0 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 100.1 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.8 | 101.0 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 4.7 | 100.0 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.6 | 100.4 | 100.0 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.1 | 100.7 | 100.3 |

Ерөнхий индекс 2021 оны 1 сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс 1.6 хувь, гэр ахуйн тавилга, бараа бүлгийн индекс 1.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөс бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашигладаг.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

Банк

Зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 1 сард 124.5 тэрбум төгрөг байгаа ба 0.9 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харицахын үлдэгдэл 2021 оны 1 сард 19.3 тэрбум төгрөг байгаа ба үүнээс иргэдийн харилцахын үлдэгдэл 16.4 тэрбум буюу 86.8 хувийг эзэлж байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл 2021 оны 1 сард 127.3 тэрбум төгрөгт хүрчээ.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

(Сая төгрөг, тоогоор)

| Үзүүлэлт | | Үлдэгдэл |
|-----------------------------------|--|------------------|
| Зээл | Нийт зээлийн үлдэгдэл | 124,537.7 |
| | Үүнээс: <i>Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл</i> | 1,728.2 |
| | <i>Чанаргүй зээлийн үлдэгдэл</i> | 1,068.5 |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгө | Нийт харилцахын үлдэгдэл | 19,282.1 |
| | Үүнээс: <i>Иргэдийн харилцахын үлдэгдэл</i> | 16,386.9 |
| | Нийт хадгаламжийн үлдэгдэл | 127,260.0 |
| | <i>Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл</i> | 122,464.6 |
| | Үүнээс: <i>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</i> | 38,685.1 |
| | <i>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</i> | 88,574.9 |
| Тоон мэдээлэл | Нийт банкны салбар, нэгжийн тоо | 45 |
| | Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо | 192 |
| | Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор) | 23488 |
| | Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор) | 109164 |
| | Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор) | 54683 |
| | Нийт АТМ-ны тоо | 27 |
| | Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо | 55078 |

Ойлголт, тодорхойлолт:

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.


2020 оны жилийн эцсийн мал тооллогоор 3310.8 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 122.1 мянга, үхэр 75.9 мянга, тэмээ 43.9 мянга, хонь 945.7 мянга, ямаа 2123.2 мянган мал байна.

Малтай 10.9 мянган өрх байгаагийн 7.9 мянга нь 72.4 хувь нь малчин өрх байна.

**Малын тоо 2020 онд
сумаар, мянган толгой**




Нийт 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 555 болж 2019 оноос 229 өрхөөр (41.3%)-аар буурчээ.




Малчин өрхийн бүлэглэлтээр хамгийн бага хувийг 2001-ээс дээш малтай өрх 16 (0.1%), 201-500 малтай өрх 3770 (34.4%)-ийг эзлэж байна.

Малтай өрхийн тоо өмнөх оноос 434 өрхөөр буюу 4.1 хувиар өссөн байна. 2019 онтой харьцуулхад малтай өрхийг малын тоо бүлэглэлтээр 10 хүртэлх малтай өрх 7.5 хувиар, 501-999 хүртэлх малтай өрх 6.4 хувиар, 1000-1499 малтай өрх 41.5 хувиар 1500-2000 малтай өрх 43.3 хувиар, 2001-ээс дээш малтай өрх 27.3 хувиар буурсан байна.



Мал сүргийн бүтэц, нийт сүрэгт эзлэх хувиар 1990 болон 2020 он



Малын хорогдол: Нэгдүгээр сарын байдлаар аймгийн хэмжээнд 28.1 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.2 дахин өссөн байна.

Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 633, үхэр 486, тэмээ 21, хонь 6601, ямаа 20439 толгой байна. Нийт хорогдлын 23.4 хувийг хонь, 72.5 хувийг ямаа эзэлж байна.


Ойлголт, тодорхойлолт:

Төл бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Том малын зүй бус хорогдол: Өвчнөөр (халдвартай, халдваргүй) болон гэнэтийн аюулаар (цас, зуд, үер, ус, гал түймэр, аянга, цахилгаан зэрэг) хорогдсон, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) улмаас хорогдсон малыг хамруулна.


2021 оны 1 дүгээр сараас 2021 оны 3 дугаар сарын уур амьсгал

Нэгдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 10-16°C, бусад нутгаар 18-26°C хүйтэн байдаг. 1 дүгээр сарын агаарын дундаж температур Говь-Алтайн нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 1**). Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Говь-Алтайн нутгаар 1-2 мм цас ордог. 1 дүгээр сарын нийлбэр хур тунадас Говь-Алтайн нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй байна (**Зураг 2**).



Зураг 1. 2021 оны 1 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)

[X – агаарын температур ОЖД – аас хүйтэн, H – агаарын температур ОЖД – ийн орчим]




Зураг 2. 1 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

[И – хур тунадас ОЖД – аас ахиу, Б – хур тунадас ОЖД – аас бага]


H – агаарын температур, хур тунадас ОЖД – ийн орчим]

Хоёрдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 6-12°C, бусад нутгаар 14-22°C хүйтэн байдаг. 2 дугаар сарын агаарын дундаж температур Говь-Алтайн нутгаар дунджийн орчим байна (**Зураг 3**). Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Говь-Алтайн зарим нутгаар 2-4 мм, бусад нутгаар 0-2 мм цас ордог. 2 дугаар сарын нийлбэр хур тунадас Говь-Алтайн нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй (**Зураг 4**).



Зураг 3. 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)

[Д – агаарын температур ОЖД – аас дулаан, Н – агаарын температур ОЖД – ийн орчим]




Зураг 4. 2 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

[И – хур тунадас ОЖД – аас ахиу, Б – хур тунадас ОЖД – аас бага


Н – агаарын температур, хур тунадас ОЖД – ийн орчим]

Гүравдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Говь-Алтайн өмнөд хэсгээр 4°C хүйтнээс 2°C дулаан, бусад нутгаар 4-12°C хүйтэн байдаг. 3 дугаар сарын агаарын дундаж температур Говь-Алтайн зарим сумдын нутгаар ОЖД-ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 5**). Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Говь-Алтайн нутгаар 0-4 мм хур тунадас ордог. 3 дугаар сарын нийлбэр хур тунадас Говь-Алтайн зарим сумдын нутгаар ОЖД – аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**Зураг 6**).



Зураг 5. 3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(°C)

[Д - агаарын температур ОЖД – аас дулаан, Н - агаарын температур ОЖД – ийн орчим]



Зураг 6. 3 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

[И - хур тунадас ОЖД – аас ахиу, Б - хур тунадас ОЖД – аас бага

Н - агаарын температур, хур тунадас ОЖД – ийн орчим]


Эх үүсвэр: УЦУОШТ МҮХэлтэс Утас: 70483093

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2021 оны 1 дүгээр сарын эцэст

ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯᠲᠡᠢ ᠠᠵᠢᠯᠭᠦᠢ ᠶᠢᠷᠭᠡᠳᠦ



Насны бүлгээр



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд



**ХӨДӨЛМӨР
LABOUR**

**БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, тайлант хугацааны эцэст
NUMBER OF REGISTERED UNEMPLOYED, at the end of period**

| Боловсролын түвшинээр | By educational level | 2017.I | 2018.I | 2019.I | 2020.I | 2021.I |
|--------------------------|--|------------|------------|------------|------------|------------|
| Бүгд | Total | 845 | 956 | 974 | 727 | 970 |
| Үүнээс: эмэгтэй | of which:female | 458 | 510 | 484 | 353 | 457 |
| Дээд боловсролтой | Higher education | 283 | 315 | 243 | 159 | 301 |
| Тусгай дунд боловсролтой | Specialized secondary education | 37 | 58 | 48 | 30 | 36 |
| Мэргэжлийн анхан шатны | Professional technical and vocational training workers | 89 | 101 | 78 | 66 | 68 |
| Бүрэн дунд | Upper secondary school | 357 | 398 | 502 | 409 | 486 |
| Суурь | Compulsory secondary school | 43 | 49 | 61 | 41 | 47 |
| Бага | Primary school | 32 | 32 | 24 | 10 | 19 |
| Боловсролгүй | Uneducated persons | 4 | 3 | 18 | 12 | 13 |

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, насны бүлгээр, 2021 оны 1 сарын эцэст
NUMBER OF UNEMPLOYED, by age group, at the end of january 2021**

| Сар Months | Бүгд Total | Үүнээс: эмэгтэй female | Үүнээс: насны бүлгээр of which:by age group | | | | | | | | | | | |
|---------------|---------------|------------------------------|---|----------------|-------|----------------|-------|----------------|-------|----------------|-------|----------------|-----|----------------|
| | | | 15-24 | Эмэгтэй female | 25-34 | Эмэгтэй female | 35-44 | Эмэгтэй female | 45-59 | Эмэгтэй female | 55-59 | Эмэгтэй female | 60+ | Эмэгтэй female |
| I | 970 | 457 | 143 | 60 | 309 | 146 | 253 | 125 | 201 | 101 | 43 | 16 | 21 | 9 |

**АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, СУМААР
NUMBER OF UNEMPLOYED, by som**

| Сум | Sum | Ажилгүйчүүдийн тоо Number of unemployed | | | | | | 1-р сар | | Өөрчлөлт % |
|------------|--------------|---|------------|------------|------------|------------|------------|-------------|--|------------|
| | | 2017.XII | 2018.XII | 2019.XII | 2020.XII | 2020 | | 2021 | | |
| | | | | | | 2020 | 2021 | | | |
| Есөнбулаг | Yesunbulag | 353 | 487 | 453 | 521 | 366 | 475 | 29.8 | | |
| Алтай | Altai | 27 | 17 | 30 | 24 | 17 | 24 | 41.2 | | |
| Баян-Уул | Bayan-Uul | 28 | 30 | 35 | 40 | 29 | 37 | 27.6 | | |
| Бигэр | Biger | 24 | 29 | 38 | 39 | 26 | 38 | 46.2 | | |
| Бугат | Bugat | 31 | 30 | 28 | 18 | 28 | 17 | -39.3 | | |
| Дарив | Darib | 12 | 54 | 40 | 26 | 24 | 23 | -4.2 | | |
| Дэлгэр | Delger | 75 | 24 | 41 | 28 | 23 | 31 | 34.8 | | |
| Жаргалан | Jargalan | 6 | 11 | 12 | 11 | 9 | 9 | 0.0 | | |
| Тайшир | Taishir | 16 | 3 | 15 | 22 | 14 | 20 | 42.9 | | |
| Тонхил | Tonhil | 11 | 30 | 30 | 42 | 39 | 43 | 10.3 | | |
| Төгрөг | Tugrug | 16 | 21 | 17 | 14 | 13 | 13 | 0.0 | | |
| Халиун | Haliun | 30 | 25 | 27 | 22 | 25 | 19 | -24.0 | | |
| Хөхморьт | Huhmorit | 16 | 12 | 34 | 27 | 19 | 30 | 57.9 | | |
| Цогт | Tsogt | 63 | 38 | 53 | 47 | 30 | 48 | 60.0 | | |
| Цээл | Tseel | 16 | 33 | 30 | 52 | 14 | 74 | 428.6 | | |
| Чандмань | Chandmani | 45 | 42 | 42 | 44 | 27 | 44 | 63.0 | | |
| Шарга | Sharga | 12 | 18 | 15 | 12 | 8 | 12 | 50.0 | | |
| Эрдэнэ | Erdene | 15 | 15 | 24 | 7 | 16 | 13 | -18.8 | | |
| ДҮН | TOTAL | 796 | 919 | 964 | 996 | 727 | 970 | 33.4 | | |

ЭРҮҮЛ МЭНД, 2021 оны 1 дүгээр сард

ᠡᠷᠦᠭᠦᠯᠡᠮᠡᠨᠳᠡ



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД
PUBLIC HEALTH OF POPULATION

| № | Сумын нэр | Soum | Төрсөн эх Women who gave births | | Эхийн эндэгдэл Maternal Deaths | | Төрсөн хүүхэд Births | | Нялхасын эндэгдэл Infant mortality | | 1-5 хүртэлх настай хүүхдийн эндэгдэл Under-five mortality | | Нийт нас баралт Deaths | | Эмнэлэгт нас баралт Deaths | |
|-----------|------------|--------------|---------------------------------------|------------|---|----------|----------------------------|------------|---|----------|--|----------|------------------------------|-----------|----------------------------------|----------|
| | | | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 |
| 1 | Есөнбулаг | Yesunbulag | 91 | 95 | | | 91 | 95 | 2 | 1 | | | 8 | 12 | 3 | 3 |
| 2 | Алтай | Altai | 2 | 1 | | | 2 | 1 | | | | | 2 | 0 | | |
| 3 | Баян-Уул | Bayan-Uul | | 1 | | | | 1 | | | | | | | | |
| 3 | Бигэр | Biger | | | | | | | | | | | | 1 | | 1 |
| 4 | Бугат | Bugat | | 1 | | | | 1 | | | | | 3 | 2 | 1 | |
| 5 | Гуулин | Gulin | | | | | | | | | | | | | | |
| 5 | Дарив | Darib | 1 | 1 | | | 1 | 1 | | 1 | | | | 1 | | |
| 6 | Дэлгэр | Delger | 1 | 1 | | | 1 | 2 | | 1 | | | 3 | 1 | | 1 |
| 7 | Жаргалан | Jargalan | | | | | | | | | | | | 1 | | 1 |
| 8 | Тайшир | Taishir | | | | | | | | | | | | | | |
| 8 | Тонхил | Tonhil | 1 | 2 | | | 1 | 2 | | | | | | | | |
| 9 | Төгрөг | Tugrug | 2 | 1 | | | 2 | 1 | | | | | | 2 | | |
| 10 | Халиун | Haliun | | | | | | | | | | | | | | |
| 10 | Хөхморьт | Huhmorit | | | | | | | | | | | | | | |
| 11 | Цогт | Tsogt | | | | | | | | | | | 1 | | | |
| 12 | Цээл | Tseel | | 1 | | | | 1 | | | | | | | | |
| 12 | Чандмань | Chandmani | 1 | 1 | | | 1 | 1 | | | | | | 1 | | |
| 13 | Шарга | Sharga | | | | | | | 1 | | | | 1 | | | |
| 14 | Эрдэнэ | Erdene | 1 | 2 | | | 1 | 2 | | | | | 1 | 0 | | |
| 15 | Баянтоорой | Bayantoroï | 1 | | | | 1 | | | | | | | | | |
| 22 | Дүн | Total | 101 | 107 | 0 | 0 | 101 | 108 | 3 | 3 | 0 | 0 | 19 | 21 | 4 | 6 |

Үргэлжлэл


| № | Сумын нэр | Soum | Цочмог халдварт өвчлөл бүгд Infectious Diseases | | Үүнээс: Of which: БЗХӨ STID | | | | | | Үргэлжлэл | | | | | | | |
|-----------|--------------------------|--------------|---|-----------|-----------------------------|----------|-----------------|----------|----------------------|----------|------------------|----------|---------------------|----------|--------------|----------|-------------|----------|
| | | | | | Трихомоназ Trichomoniasis | | Тэмбүү Syphilis | | Заг хүйтэн Gonorrhea | | Гепатит Hepatite | | Сүрьеэ Tuberculosis | | Улаан бурхан | | Бусад Other | |
| | | | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 | 2020 | 2021 |
| 1 | Есөнбулаг | Yesunbulag | 15 | 12 | 1 | 1 | 3 | 3 | 6 | 5 | | | 1 | 1 | | | 4 | 2 |
| 2 | Алтай | Altai | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 3 | Баян-Уул | Bayan-Uul | 0 | 1 | | | | | | | | | | | | | | 1 |
| 3 | Бигэр | Biger | 1 | 0 | | | | | | | | | 1 | | | | | |
| 4 | Бугат | Bugat | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 5 | Гуулин | Gulin | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 5 | Дарив | Darib | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 6 | Дэлгэр | Delger | 0 | 1 | | | | | 0 | | | | | 1 | | | | |
| 7 | Жаргалан | Jargalan | 1 | 1 | | | 1 | 1 | | | | | | | | | | |
| 8 | Тайшир | Taishir | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 8 | Тонхил | Tonhil | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 9 | Төгрөг | Tugrug | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 10 | Халиун | Haliun | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 10 | Хөхморьт | Huhmorit | 1 | 0 | | | | | 1 | | | | | | | | | |
| 11 | Цогт | Tsogt | 2 | 0 | | | 1 | | 1 | | | | | | | | | |
| 12 | Цээл | Tseel | 0 | 1 | | | | | | | | | | 1 | | | | |
| 12 | Чандмань | Chandmani | 0 | 1 | | | | | | | | | | 1 | | | | |
| 13 | Шарга | Sharga | 2 | 0 | | | | | | | | | 1 | | | | | 1 |
| 14 | Эрдэнэ | Erdene | 0 | 0 | | | | | 0 | | | | | | | | | |
| 15 | Баянтоорой Харьяаллын | Bayantoroi | 0 | 0 | | | | | | | | | | | | | | |
| 16 | бус | | 4 | 2 | 2 | | 1 | 1 | 1 | 1 | 0 | 0 | | | | | | |
| 22 | Дүн | Total | 26 | 19 | 3 | 1 | 6 | 5 | 9 | 6 | 0 | 0 | 3 | 4 | 0 | 0 | 5 | 3 |



НИЙГМИЙН ДААТГАЛ, 2021 оны 1 дүгээр сард

ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ
ᠳᠠᠠᠲᠭᠠᠯ
ᠰᠠᠨ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая.төгрөг



*ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин


НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД¹

Албан журмаар
даатгуулагчид


761

Сайн дураар
даатгуулагч

830



ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИД ХАМРАГДАГЧИД



Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, олгосон тэтгэвэр, сая төг

| Сум | 2020.I | | 2021.I | | 2021.I/2020.I*100% | |
|-------------|------------------------------|----------------------------------|------------------------------|----------------------------------|------------------------------|----------------------------------|
| | Тэтгэвэр авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ | Тэтгэвэр авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ | Тэтгэвэр авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ |
| Бүгд | 7913 | 2631.63 | 8681 | 3192.5 | 109.7 | 121.3 |
| Есөнбулаг | 2636 | 959.335 | 2784 | 1131.19 | 105.6 | 117.9 |
| Алтай | 235 | 90.52 | 277 | 112.75 | 117.9 | 124.6 |
| Баян-Уул | 394 | 124.84 | 441 | 149.69 | 111.9 | 119.9 |
| Бигэр | 305 | 97.69 | 344 | 120.54 | 112.8 | 123.4 |
| Бугат | 318 | 101.26 | 351 | 121.61 | 110.4 | 120.1 |
| Дарив | 271 | 86.26 | 306 | 108.01 | 112.9 | 125.2 |
| Дэлгэр | 302 | 94.23 | 341 | 115.94 | 112.9 | 123.0 |
| Жаргалан | 271 | 83.47 | 291 | 100.56 | 107.4 | 120.5 |
| Тайшир | 201 | 64.5 | 239 | 84.51 | 118.9 | 131.0 |
| Тонхил | 302 | 96.84 | 339 | 121.3 | 112.3 | 125.3 |
| Төгрөг | 289 | 91.16 | 325 | 111.08 | 112.5 | 121.9 |
| Халиун | 342 | 103.82 | 392 | 133.44 | 114.6 | 128.5 |
| Хөхморьт | 312 | 97.9 | 344 | 123.94 | 110.3 | 126.6 |
| Цогт | 385 | 119.61 | 417 | 144.83 | 108.3 | 121.1 |
| Цээл | 276 | 85.235 | 312 | 104.1 | 113.0 | 122.1 |
| Чандмань | 288 | 86.51 | 309 | 107.3 | 107.3 | 124.0 |
| Шарга | 279 | 87.31 | 321 | 108.67 | 115.1 | 124.5 |
| Эрдэнэ | 278 | 85.41 | 298 | 100.6 | 107.2 | 117.8 |
| Гуулин | 109 | 38.03 | 119 | 45.33 | 109.2 | 119.2 |
| Баянтоорой | 120 | 37.7 | 131 | 47.11 | 109.2 | 125.0 |

Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авагчдын тоо, олгосон тэтгэмж, сая төг

| Сум | 2020.I | | 2021.I | | 2021.I/2020.I*100% | |
|-------------|-----------------------------|----------------------------------|-----------------------------|----------------------------------|-----------------------------|----------------------------------|
| | Тэтгэмж авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ | Тэтгэмж авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ | Тэтгэмж авагчид /тоо/ | Олгосон тэтгэвэр /сая.төг/ |
| Бүгд | 142 | 112.84 | 182 | 203.59 | 128.2 | 180.4 |
| Есөнбулаг | 86 | 72.92 | 98 | 102.63 | 114.0 | 140.7 |
| Алтай | 6 | 2.26 | 8 | 5.92 | 133.3 | 261.9 |
| Баян-Уул | 2 | 1.21 | 0 | 0 | 0.0 | 0.0 |
| Бигэр | 2 | 1.63 | 3 | 3.97 | 150.0 | 243.6 |
| Бугат | 3 | 3.45 | 4 | 11.69 | 133.3 | 338.8 |
| Дарив | 1 | 0.63 | 1 | 2.34 | 100.0 | 371.4 |
| Дэлгэр | 4 | 4.23 | 6 | 8.95 | 150.0 | 211.6 |
| Жаргалан | 2 | 1.46 | 4 | 3.41 | 200.0 | 233.6 |
| Тайшир | 2 | 1.15 | 3 | 1.99 | 150.0 | 173.0 |
| Тонхил | 4 | 3.86 | 5 | 5.99 | 125.0 | 155.2 |
| Төгрөг | 2 | 2.58 | 3 | 6.88 | 150.0 | 266.7 |
| Халиун | 5 | 3.69 | 7 | 8.77 | 140.0 | 237.7 |
| Хөхморьт | 1 | 0.04 | 2 | 4.72 | 200.0 | 11800.0 |
| Цогт | 7 | 2.58 | 12 | 6.68 | 171.4 | 258.9 |
| Цээл | 3 | 1.45 | 5 | 6.91 | 166.7 | 476.6 |
| Чандмань | 3 | 1.96 | 4 | 5.24 | 133.3 | 267.3 |
| Шарга | 2 | 1.64 | 5 | 5.13 | 250.0 | 312.8 |
| Эрдэнэ | 6 | 5.1 | 9 | 9.81 | 150.0 | 192.4 |
| Гуулин | 0 | 0 | 1 | 1 | | |
| Баянтоорой | 1 | 1 | 2 | 1.56 | 200.0 | 156.0 |

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
GOVI-ALTAI AIMAGS GOVERNMENT REVENUE, by classification of revenue

мян.мөe thous.tug

| ОРЛОГЫН ТӨРӨЛ | INCOME TYPE | Төлөвлөгөө Project | * Гүйцэтгэл Performance | Хувь Rate |
|--|-------------|-----------------------|----------------------------|--------------|
| НИЙТ ОРЛОГО | | 744335.2 | 822620.6 | 110.5 |
| УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОСОН | | | | |
| САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ | | 0.0 | 0.0 | 0.0 |
| ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛЭГ | | 0.0 | 0.0 | 0.0 |
| ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН | | 0.0 | 0.0 | 0.0 |
| ШИЛЖЭЭГҮЙ ҮЛДЭГДЭЛ | | 0.0 | 0.0 | 0.0 |
| ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО | | 626631.2 | 679835.9 | 108.5 |
| 1. ТАТВАРЫН ОРЛОГО | | 572021.2 | 617094.6 | 107.9 |
| 1.1 Орлогын албан татвар | | 510698.7 | 535184.6 | 104.8 |
| 1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | | 510698.7 | 535184.6 | 104.8 |
| Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | | 400000.0 | 331061.2 | 82.8 |
| Үйл ажиллагааны орлого | | 9372.0 | 26497.1 | 282.7 |
| Хөрөнгийн орлого | | 88816.7 | 170202.4 | 191.6 |
| Хөрөнгө борлуулсны орлого | | 5800.0 | 5441.8 | 0.0 |
| Шууд бус орлого | | 6710.0 | 1982.1 | 29.5 |
| 1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.2 Хөрөнгийн албан татвар | | 6489.1 | 30545.9 | 470.7 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | | 5000.0 | 14284.1 | 285.7 |
| Галт зэвсгийн албан татвар | | 1250.0 | 1560.0 | 124.8 |
| татвар | | 239.1 | 14701.8 | 6148.8 |
| Малд ногдуулах албан татвар | | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.3 Бусад татвар, төлбөр, хураамж | | 54833.4 | 51364.1 | 93.7 |
| 1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | | 30603.0 | 14183.2 | 46.3 |
| Улсын тэмдэгтийн хураамж | | 14286.0 | 11022.0 | 77.2 |
| Улсын тэмдэгтийн хураамжийн буцаан олголт | | -1000.0 | -277.1 | 27.7 |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | | 10.0 | 150.0 | 0.0 |
| Хог хаягдлын хураамжийн төлбөр | | 17307.0 | 3288.3 | 19.0 |
| 1.3.2 Газрын төлбөр | | 21230.4 | 25301.5 | 119.2 |
| Үүнээс: Газрын төлбөр | | 21230.4 | 25301.5 | 119.2 |
| Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт | | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | | 3000.0 | 11746.6 | 391.6 |
| Үүнээс: Ойн нөөц ашигласны төлбөр | | 0.0 | 0.0 | 0.0 |
| Ан, амьтны нөөц ашигласны төлбөр | | 0.0 | 0.0 | 0.0 |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | | 3000.0 | 11746.6 | 391.6 |
| Байгалийн ургамал ашигласны төлбөр | | 0.0 | 0.0 | 0.0 |
| 1.3.4 Бусад татвар | | 0.0 | 132.8 | 0.0 |
| 2. Татварын бус орлого | | 54610.0 | 62041.3 | 113.6 |
| Хүү, торгуулийн орлого | | 54490.0 | 55104.4 | 101.1 |
| Төсвийн байгууллагын өөрийн орлого | | 0.0 | 0.0 | 0.0 |
| Түрээсийн орлого | | 120.0 | 579.0 | 482.5 |
| Бусад орлого | | 0.0 | 6357.9 | 0.0 |
| 3. Хөрөнгийн орлого | | 0.0 | 700.0 | 0.0 |
| Өмч хувьчлалын орлого | | 0.0 | 700.0 | 0.0 |
| УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО | | 117704.0 | 142784.7 | 121.3 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | | 8980.0 | 23913.6 | 266.3 |
| НӨАТатвар | | 105320.0 | 117807.2 | 111.9 |
| Онцгой албан татвар | | 1700.0 | 0.0 | 0.0 |
| Агаарын бохирдлын төлбөр | | 1700.0 | 1063.9 | 62.6 |
| Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр | | 4.0 | 0.0 | 0.0 |
| Ус бохирдуулсны төлбөр | | 0.0 | 0.0 | 0.0 |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ сумаар
PERFORMANCE REVENUE **sum**

| № | Сум | Soum | мян.төг thous.tug | | |
|------------|-------------------|----------------------|--------------------------------------|--|--------------|
| | | | Нийт орлого Төлөвлөгөө Project | Gross income * Гүйцэтгэл Performance | Хувь Rate |
| 1 | Есөнбулаг | Yesunbulag | 97,950.0 | 78,449.5 | 97.6 |
| 2 | Алтай | Altai | 3,345.0 | 7,420.1 | 104.6 |
| 3 | Баян-Уул | Bayn-Uul | 3,800.0 | 8,087.2 | 123.1 |
| 4 | Бигэр | Biger | 3,562.7 | 11,793.3 | 156.5 |
| 5 | Бугат | Bugat | 3,500.0 | 9,507.7 | 142.3 |
| 6 | Дарив | Dariv | 6,125.0 | 9,546.7 | 113.6 |
| 7 | Дэлгэр | Delger | 1,970.0 | 5,783.2 | 130.6 |
| 8 | Жаргалан | Jargalan | 3,130.0 | 7,677.8 | 143.7 |
| 9 | Тайшир | Taishir | 437.0 | 4,784.8 | 116.3 |
| 10 | Тонхил | Tonhil | 6,217.0 | 21,303.0 | 150.0 |
| 11 | Төгрөг | Tugrug | 3,790.0 | 7,828.6 | 114.9 |
| 12 | Халиун | Khaliun | 1,457.0 | 6,722.7 | 133.2 |
| 13 | Хөхморьт | Khukhmorit | 2,315.0 | 3,168.2 | 111.3 |
| 14 | Цогт | Tsogt | 2,630.0 | 14,899.4 | 106.5 |
| 15 | Цээл | Tseel | 5,826.4 | 14,246.4 | 117.5 |
| 16 | Чандмань | Chandmani | 3,910.0 | 14,920.8 | 123.6 |
| 17 | Шарга | Sharga | 2,215.0 | 6,046.1 | 129.6 |
| 18 | Эрдэнэ | Erdene | 2,752.0 | 8,882.4 | 182.0 |
| 19 | Баянтоорой тосгон | Bayntooroi | 640.0 | 6,479.8 | 143.7 |
| 20 | Гуулин тосгон | Guulin | 820.0 | 3,333.1 | 182.0 |
| 21 | Татварын хэлтэс | Straight communicant | 470,239.1 | 428,955.1 | 111.6 |
| Дүн | | | 626,631.2 | 679,835.9 | 112.0 |

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

* урьдчилсан гүйцэтгэл

* Times more

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
EXPENDITURE OF PROVINCIAL GOVERNMENT

/мян.төг, thous.tug/

| Төрөл type | Төсөв budget | * Гүйцэтгэл Performance | Хувь Rate |
|---|---------------------|----------------------------|--------------|
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 73,826,644.4 | 4,104,376.1 | 5.6 |
| НИЙТ ЗАРЛАГА | 70,361,153.1 | 4,060,803.7 | 5.8 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 87,319,426.3 | 4,094,743.2 | 4.7 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 60,504,020.5 | 4,049,069.5 | 6.7 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 38,527,348.8 | 2,931,583.3 | 7.6 |
| Үндсэн цалин | 32,312,545.9 | 2,479,625.3 | 7.7 |
| Нэмэгдэл | 2,193,794.1 | 190,474.3 | 8.7 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 183,755.1 | 25,653.4 | 14.0 |
| Урамшуулал | 1,315,841.6 | 20,027.9 | 1.5 |
| Гэрээт ажлын хөлс | 2,521,412.1 | 215,802.4 | 8.6 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,160,072.5 | 363,812.9 | 7.1 |
| Тэтгэврийн даатгал | 3,619,844.5 | 259,055.3 | 7.2 |
| Тэтгэмжийн даатгал | 384,268.1 | 24,521.9 | 6.4 |
| ҮОМШӨ-ний даатгал | 308,015.1 | 22,502.3 | 7.3 |
| Ажилгүйдлийн даатгал | 77,015.8 | 5,273.9 | 6.8 |
| Эрүүл мэндийн даатгал | 770,929.0 | 52,459.5 | 6.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 6,438,654.1 | 524,022.5 | 8.1 |
| Гэрэл, цахилгаан | 460,620.8 | 20,931.8 | 4.5 |
| Түлш, халаалт | 5,766,917.4 | 498,996.4 | 8.7 |
| Цэвэр, бохир ус | 211,115.9 | 4,094.3 | 1.9 |
| Байрны түрээс | 0.0 | 0.0 | 0.0 |
| Хангамж, бараа материалын зардал | 1,508,694.4 | 38,547.5 | 2.6 |
| Бичиг хэрэг | 188,795.9 | 4,261.2 | 2.3 |
| Тээвэр, шатахуун | 885,760.4 | 21,760.1 | 2.5 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 153,781.1 | 4,836.7 | 3.1 |
| Ном, хэвлэл | 40,275.3 | 3,259.6 | 8.1 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 56,598.2 | 460.0 | 0.8 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 183,483.5 | 3,970.0 | 2.2 |
| Нормативт зардал | 3,637,244.9 | 12,543.7 | 0.3 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 353,391.7 | 8,432.9 | 2.4 |
| Хоол, хүнс | 3,178,781.2 | 4,007.8 | 0.1 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 105,072.0 | 103.0 | 0.1 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 754,915.0 | 34,292.8 | 4.5 |
| Багаж, техник, хэрэгсэл | 258,252.2 | 8,844.3 | 3.4 |
| Тавилга | 144,453.7 | 12,890.0 | 8.9 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 15,870.0 | 298.5 | 1.9 |
| Урсгал засвар | 336,339.1 | 12,260.0 | 3.6 |
| Томиллолт, зочны зардал | 288,220.0 | 4,318.0 | 1.5 |
| Гадаад албан томилолт | 288,220.0 | 4,318.0 | 0.0 |
| Дотоод албан томилолт | 2,413,521.9 | 75,785.8 | 3.1 |
